



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/98

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны XII/21 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, аймгийн Засаг даргын 2023 оны А/08 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн эко аялал жуулчлал болох мөсөн загасчлалын тэмцээнийг "Тэвэр дүүрэн сэтгэл" ХХК-тай хамтран зохион байгуулсугай.

2. Мөсөн загасчлалын тэмцээнд шаардагдах 1,210,000 (Нэг сая хоёр зуун арван мянга) төгрөгийн дэмжлэгийг Байгаль хамгаалах сангийн Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжих зардлын Эко аялал жуулчлалын арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх төсөл, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

